ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2026 он 2-р улирал )
УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | Нийт ажилчид | 100% | Тайлангийн хугацаанд 605 эрүүл мэндийн байгууллагын албан хаагчид 20 удаагийн эмч нарын яриагаар давхардсан тоогоор 1952 эмч сургалт, яриа, мэдээлэл (эмч нарын яриа)-д оролцсон.<br>2026.04 сард нийт 98 шинэ ажилтан, суралцагч нарт зориулсан нэг удаагийн чиглүүлэх сургалтыг УХТЭ-ийн дотоод журам, эрүүл мэндийн анхан шатны маягт хөтлөлт, мэдээллийн технологийн аюулгүй байдал, хувь хүний нууцын хамгаалал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал, байгууллагын соёл сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн хөдөлмөр аюулгүй байдлын мэргэжилтэн хөтөлбөр, хуваарийн дагуу 2026.06.01-ний өдрөөс эмнэлгийн тоног төхөөрөмж, инженер байгууламжийн алба, аж ахуй, хангамж, үйлчилгээний алба, автогарашийн хэсэг, сургалтын албаны нийт 60 ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдлын сургалтыг хийсэн. 2026.05 сард дэмжих алба, эмзүйн албаны нийт 20 ажилтан Онцгой байдлын албанаас зохион байгуулагдсан гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан.<br>Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг Эмнэл зүйн сургагч багш бэлдэх сургалтад нийт 16 эмч суралцан гэрчилгээ авсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | 99 | 100% | Эмнэл зүйн зохицуулалтын алба, эм зүйн алба, мэдээллийн технологийн алба, ЭМТҮЧАБЭ алба, хөдалмарийн аюулгүй байдлын мэргэжилтэн, гэрээт сэтгэл зүйч эмч өөрсдийн төлөвлөгөөний дагуу ажлын байран дахь сургалтыг тасаг, албадаар хийсэн.<br>УХТЭ, Зүүн 5 аймаг, алслагдсан 3 дүүргийн хамтын ажиллагааны хүрээнд Сүхбаатар аймаг болон Дорноговь аймгийн нийт 6 эмч, ажилтанг хүний нөөцийн алба, дүрс оношилгооны төвд ажлын байран дахь сургалтад хамруулсан.<br>УХТЭ-УГТЭ ийн хамтын ажиллагааны хүрээнд Мэдрэлийн төвийн 10 сувилагчийг УГТЭ-ийн Харвалтын тасагт ажлын байран дахь сургалтад хамруулсан.<br>Бөөр шилжүүлэн суулгах багийн 23 гишүүн УНТЭ-т ажлын байран дахь сургалтад тайлант хугацаанд хамрагдлаа.<br>2026.06.01-ний өдрөөс эмнэлгийн тоног төхөөрөмж, инженер байгууламжийн алба, аж ахуй, хангамж, үйлчилгээний алба, автогарашийн хэсэг, сургалтын албаны нийт 60 ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдлын сургалтыг хийсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Мэргэшүүлэх сургалт | 50 | 100% | Бөөрний мэс засал, Ерөнхий мэс засал, Эмэгтэйчүүдийн мэс засал, Мэдрэлийн төв, Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг, Эмнэлзүйн зохицуулалтын албаны нийт 20 эмч УХТЭ болон УНТЭ-т зохион байгуулагддаг хэвлийн хөндийн дурангийн мэс засал, дурангийн онош зүй, эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал, тархины цахилгаан бичлэг, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгасны дараах хяналт чиглэлийн төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.<br>Мэдрэлийн мэс заслын тасаг, Тусгай тасаг, Амбулатори, Бөөрний мэс заслын тасаг, нэгдсэн лабораторийн тасаг, МЭЭТ, Ерөнхий мэс засал, ЗССТ-ын нийт 30 эмч, эмнэлгийн мэргэжилтэн БНСУ, БНХАУ, Энэтхэг улсад мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтанд хамрагдаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | 47 | 100% | УХТЭ, Зүүн 5 аймаг, алслагдсан 3 дүүргийн хамтын ажиллагааны хүрээнд Сүхбаатар аймаг болон Дорноговь аймгийн нийт 6 эмч, ажилтанг хүний нөөцийн алба, дүрс оношилгооны төвд ажлын байран дахь сургалтад хамруулсан.<br>УХТЭ-УГТЭ ийн хамтын ажиллагааны хүрээнд Мэдрэлийн төвийн 10 сувилагчийг УГТЭ-ийн Харвалтын тасагт ажлын байран дахь сургалтад хамруулсан.<br>Бөөр шилжүүлэн суулгах багийн 23 гишүүн УНТЭ-т ажлын байран дахь сургалтад тайлант хугацаанд хамрагдлаа.<br><br>БНСУ-ын зочин профессорууд ЗССТ болон Элэг шилжүүлэн суулгах мэс заслын үед хамтран ажилласан.<br>ХБЭСТ-ын эмч Үүрийнтуяа, Мишээл, Дүрс оношилгооны тасгийн дарга Эрдэнэбулган, эмч Ууганбаяр, Шаравжамц, Мэдрэлийн төвийн дарга Дуламрагчаа нар БНСУ, Япон улсад олон улсын хуралд оролцон аман болон ханан илтгэл хэлэлцүүлсэн. |
| | | | Бусад | Эмнэлзүйн хэсгийн нийт ажилчид | 100% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн дагуу Дотрын анагаах судлал, Яаралтай тусламж судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал, Эрчимт эмчилгээ судлал, Дүрс оношилгоо судлал, Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлалаар суралцагч нарыг УНТЭ, УГТЭ, НӨАГ, ХСҮТ, ХӨСҮГ, СЭМҮТ, НААГ, ГССҮТ, ЭХЭМҮТ-д сургалтын тойролт хийлгэсэн. |
| | | 1.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 605 | 100% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Эмнэлгийн дотоод сургалт болон эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж байна. Тасаг, албадын 2026 оны захиалгын дагуу нийт 20 эмчийг эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад тайланг хугацаанд хамруулан ажилласан. |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 480 | | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 125 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Удирдах албан тушаалтан | 2 | | Ерөнхий захирал болон Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал Удирдлагын академийн Эрүүл мэндийн удирдлага сургалтад хамрагдсан. |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 10 | | |
| | | 1.3. | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад | 605 | 100% | Мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 2026 оны хүний нөөцийн сургалтын төлөвлөлтийн дагуу 100% хэрэгжсэн бол байгууллагуудын дотоод сургалт, зайн сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулан ажилласан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эзлэх хувь | | | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч эмнэлгийн мэргэжилтнүүд HRDS (hdc.gov.mn) программаар хүсэлт илгээж багц цагийн сургалтад хамрагдан багц цагаа бүрдүүлсэн. |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1. | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 7 | 100% | Амьд донороос бөөр шилжүүлэн суулгах ажлын хүрээнд Бөөр шилжүүлэн суулгах багийн нийт 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн БНСУ-д сургалтад хамрагдаж байна. Зардлын хэлбэр: зохион байгуулагч тал |
| | | 2.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 30 | 100% | Бөөрний эмгэгийн эмгэг лабораторийн шинжилгээ чиглэлээр НЛТ-ын их эмч Ш.Болортуяа, лаборант Мөнхтулга нар Тайван улсын Тайваны их сургуулийн эмнэлэгт нэг сарын сургалтад хамрагдсан. Зардлын хэлбэр: зохион байгуулагч тал |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 26 | 100% | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 4 | 100% | Тусгай тасгийн их эмч Мөнхжаргал Эмнэлгийн удирдлага, менежмент чиглэлээр Энэтхэг улсад 14 хоногийн сургалтад хамрагдсан. Зардлын хэлбэр: Энэтхэг улсын засгийн газрын тэтгэлэг |
| | | | Удирдах албан тушаалтан | 2 | 100% | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 28 | 100% | ЗССТ-ын эмч Сүхбаяр, Отгонтуяа, сувилагч Аззаяа, Цэрэнпагма нар зүрхний эмгэгийн оношилгоо, эмчилгээ чиглэлээр БНСУ-д сургалтад хамрагдаж байна.Зардлын хэлбэр: зохион байгуулагч тал |
| | | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | | | Мэдрэлийн мэс заслын тасгийн Э.Анхбаяр БНСУ-ын Bucheon St. Mary's Hospital-д 14 хоногийн сургалтад хамрагдан мэргэжил дээшлүүлсэн. Зардлын хэлбэр: ЭМХТ<br>Амбулаторийн тасгийн үе мөч судлалын эмч Өнөрцэцэг, НЛТ-ын эмгэг судлаач эмч Хүслэн нар БНХАУ-ын Өвөр Монголд мэргэжил дээшлүүлэх сургалтад 2026.06.08-ны өдрөөс 06.22-ны өдрийн хооронд хамрагдаж байна. Зардлын хэлбэр: Эмэгтэйчүүдийн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | | | Төрийн зардлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаачдын үндсэн цалинг Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын дагуу, Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтаар 5 жил тутамд мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 56/97 дугаар хамтарсан тушаал, байгуулагын дотоод журмын дагуу 3 хүртэлх сарын үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас гэрээний дагуу төлж байна. |
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 100% | 100% | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/446 дугаар тушаалаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн бүтэц дүрэм, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. 2026 оны ii дүгээр улиралын дунджаар 602 ажилтны орон тоотойгоор ажиллаж байна |
| Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | | | | | |
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | Цалин 22.776.4 сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 44% | Урамшуулал 2.426.1сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 8% | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5, 25, 395, 276, 2018 оны 382 дугаар 2022 оны 107 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллаж байна.Биелэлт нь 98%.-тай байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл 1.287.329.2 сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 5%.. | · | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 дугаар тушаалаар тогтоож өгсөн эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаар 2025 онд 1.287.329.2 сая төгрөг зарцуулж, нийт төсвийн 5%- ийг эзэлж байна. Биелэлт нь 100% байна. |
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 100% | 100% | Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ болон эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 2024 онд Улсын хоёрдугаар төв эмнэлгээс дахин боловсруулсан асуумжийн дагуу Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн асуумж нь 7 бүлэг, 26 асуулттай судалгааны асуумжаар, цахим хэлбэрээр авсан. 2026 оны 2 дугаар улирлын байдлаар “Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 131 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан. Ерөнхий сэтгэл ханамжийн хувь 68.6% (маш сайн, сайн) байна. |
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 90% | 89,5% | УХТЭ-ийн ажилтнуудын урдчилан сэргийлэх үзлэгийг 2026 оны 04-р сарын 01-наас 2026 оны 6-р сарын 01-ны хооронд зохион байгуулагдсан. Нийт 687 ажилтнаас 615 ажилтан үзлэгт хамрагдаж, үзлэгийн хамрагдалт 95.08% байна. Ажилтнуудын дунд 13 бүлгийн 88 гаруй эмгэг байгаагаас дараах эрхтэн тогтолцооны өвчлөлүүд байна. Эрүүл мэндийн салбарын ажилчдыг хуваарийн дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан. 2025 онд шинээр В гепатит 1 илэрсэн.<br>УХТЭ-ийн Хүүхдийн тасаг, Халдвар хяналтын алба хамтран Гепатит В вирусийн эсрэг тарилгыг нийт 232 хүн/тун, Томуугийн эсрэг тарилгыг 323 хүн/тун, ХПВ-ийн эсрэг тарилгыг 217 хүн/тун, Улаанбурхан улаануудын эсрэг тарилгыг 300 хүн/тун тус бүр дархлаажуулалт хийгдсэн. Тайлангийн жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 63 эрүүл мэндийн ажилтан хэвтэн эмчлүүлсэн. Мөн нийт үзлэгт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдсан ажилтнуудын 20% орчим нь хяналтанд байх 3% орчим нь онош тодруулах шаардлагатай байсан. |
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | 90% | 89,5% | Нийт албан хаагчдын 89,5% нь эрүүл мэндийн үзлэгт 615 ажилтан хамрагдсан байна. |
| 7. | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ 19.800.000/ арван есөн сая найман зуун мянган төгрөг/ | Төлөвлөлтийн дагуу | Тайлант оны гүйцэтгэлээр | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн байгууллагууд Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулан ажилтны нийгмийн баталгааны чиглэлээр тодорхой заалтуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. эрүүл мэндийн тухай хуулийн 29.2, 29.5 дугаар заалтаар зүйлийн дагуу 9 эмнэлгийн мэргэжилтэнд 19,800,000 төгрөг зарцуулсан.. Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ажилласан нийт эрүүл мэндийн ажилтнуудын 95 % хамрагдсан. |

ХЯНАСАН: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР Б.ЖАВХАА

НЭГТГЭСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР П.УЯНГАСАЙХАН